

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

Даяаршлын эринд ажиллаж, амьдрах чадвартай, өндөр мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэж, Монгол орныхоо одоо, ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулна.

ЗОХИОМЖ ХЭВЛЭЛИЙН ЗОРИЛГО

Зохиомж дээд сургуулийн эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтанууд болон бакалавр, магистрын зэргээр өдөр болон оройн ангид сурч буй нийт оюутануудыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах орчныг бүрдүүлэхэд оршино.

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



БИЗНЕСИЙН УХААНЫ ТЭНХИМИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

Чанартай сургалт, судалгаа, үйлчилгээ бүхий хөтөлбөрөөр иргэдийн оюуны чадварыг сайжруулж нийгмийн хөгжлийг урагшлуулна.



Эрхэм оюутнууд аа,
Олон Улсын Бизнес Технологийн Зохиомж Дээд сургууль нь Монгол Улсын дээд боловсролын хурдацтай хөгжин дэвшиж дүй тэргүүний байгууллага юм.

Тус сургуульд элсэн орсон эх орны чадварлаг ирээдүй оюутан залуус та бүхний нэгэн цөийн түүхийг амжилт бүтээл, амьдралаараа дичилцэж гэгээн цүйлэт хөтлөж замыг бид халтгаа дүй болгохоор эрдмийн их өргөөндөө журан цугларлаа. Эх орон, хүн төрөлхтний хүмүүнлэг цүйлэт хувь нэмрээ оруулах, Зохиомж их сургуулийг цогцлоож зорилт бидэнд бий.

Хүн бүгдэд адил эхлэл, ижил заяа, боломж байдаг чамьдралд олон өнгө зэрэгцэн байдаг. Хичээж, өөрийгөө дайчлан суралцаж чадаан нь эрдэм ухааныг олж авч насан туршидаа ухаанарт амьдралаа зориулах мэргэжлээ чадварлаг эзэмшдэг.

Амжилтын шигдэт түлхүүр-хичээл зүтгэл билээ. Эрхэм оюутнууд та нартаа амжилт хүсье.

Б.ЦОГТМБАЯР

Валютын ханш

	АНУ доллар	1,862.36
	Евро	2,340.71
	Японы иен	16.75
	Швейцар франк	1,940.56
	Шведийн крон	253.64
	Английн фунт	2,978.29
	ОХУ-ын рубль	44.42
	БНХАУ-н юань	304.81
	БНСУ-ын вон	1.75
	Канадын доллар	1,661.86
	Малайзын ринггит	566.07
	Туркийн лира	847.70



Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үе дэх татварын алба, татвар төлөгчийн харилцааны тухай зөвлөмж

Энэхүү зөвлөмжийн зорилго нь татвар төлөгчдөд татварын хяналт шалгалтын зорилго, ач холбогдлыг ойлгуулах, татварын хяналт шалгалтын явцад татвар төлөгч болон татварын албаны хуулиар хүлээсэн үүрэг, тогтоосон эрх, баримтлах ёс зүйг тодорхой болгон практикт хэрэгжүүлэхэд оршино.

Татварын хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэх Татварын албаны байцаагч нь татвар төлөгч тантай Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу шударгаар харилцахаа илэрхийлж, шалгалтын явцад баримтлах хууль, дүрэм, тухайн нөхцөлд та ямар үүрэг хариуцлага хүлээж, эрх эдлэхийг тайлбарлаж өгнө.

Татварын алба таныг Үндсэн хуулиар хүлээсэн татвар төлөх үүргээ биелүүлэхэд төлбөл зохих татвараа илүү ч үгүй, дутуу ч үгүй төлбөл зохих хэмжээний татвараа төлөхийг шаардаж, үүнийг биелүүлэхэд тань бүхий л талаар туслана. Үүнд хүрэхийн тулд таны тайлагнасан татварын ногдуулалт, төлөлт зөв эсэхийг тодорхойлох үүднээс шалгадаг.

Татварын алба, түүний ажилтнууд татварын хууль, тогтоомжийг шударгаар хэрэгжүүлэн ажиллаж байгаа гэдэгт та итгэлтэй байж болно.

Татварын хяналт шалгалтыг татвар төлөгч хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг шалгаж, зөрчил дутагдлыг илрүүлэх, тохирсон хариуцлага ногдуулах, цаашид татвар төлөгчдийг татварын аливаа зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хийдэг. Өөрөөр хэлбэл татвараас зугтаах явдлыг зогсоох, улмаар бүх систем шударга явах нөхцлийг бүрдүүлэх, татварын хууль тогтоомжийг нийт иргэд, аж ахуйн нэгжид адил тэгш мөрдүүлэх зорилгоор татварын хяналт шалгалт хийж байгаа юм.

Та татварын албатай авилгагүй орчинд харилцаж байгаадаа итгэлтэй байгаарай.

ХОЁР. ШАЛГАЛТЫГ ХЭРХЭН ЯВУУЛДАГ ВЭ ?

□ Танд шалгалт хийх тухайгаа татварын албанаас мэдэгдэл хүргүүлэх, утсаар, цахим хэлбэрээр урьдчилан мэдэгдэнэ.

□ Шалгалтын ажлыг эхлэхдээ танд татварын шалгалт хийх томилолт, удирдамжийг урьдчилан танилцуулах бөгөөд та ямар эрх

эдэлж, үүрэг хүлээх ёстойг байцаагч тайлбарлана.

□ Шалгалттай холбогдуулан танаас ямар баримт материал, мэдээлэл авахыг хүсч байгаагаа мэдэгдэнэ.

□ Татвар төлөгч та шалгалт хийх тухай татварын албаны мэдэгдэл аваад холбогдох баримт материал, тайлан тэнцлээ бэлдэж, байцаагчдыг ажиллах боломж нөхцлөөр хангах үүрэгтэй.

□ Та томилолтонд заасан хугацаанд шалгуулах ёстой. Хэрэв танд ямар нэг хүндэтгэн үзэх шалтгаан гарч шалгалтыг хойшлуулах шаардлага гарсан бол энэ тухайгаа албан бичгээр татварын албанд мэдэгдэнэ.

□ Таны тайлан тэнцлийн тоон үзүүлэлтийг үндсэн баримт бүртгэлд тулгуурлан шалгаж, төлбөл зохих татварын хэмжээг тогтоож, татвараа дутуу төлсөн бол нөхөн төлүүлж, хуульд заасан хариуцлага хүлээлгэх ба илүү төлсөн бол бусад татварын өр, дараа сарын төлөх татварт суутган тооцох буюу буцаан олгох асуудлыг шийдвэрлэн зохицуулна.

□ Хэрэв тооцооллын энгийн алдаа байвал байцаагч түүнийг шууд засаж, ямар тоо зассан тухайгаа танд мэдэгдэнэ.

□ Байцаагч танай үйл ажиллагааг олон талаас нь төрөл бүрийн аргаар шалгах боломжтой. Таны тайланд байгаа мэдээллийг санхүүгийн баримт материалын хүрээнд шалгахаас гадна танай үйл ажиллагаатай холбоотой бусад эх үүсвэрээс авсан мэдээллүүдтэй тулган шалгана.

□ Таны тайланг буруу гэж үзэн зарим зүйлийг тодотгох шаардлагатай бол байцаагч энэ тухай танд мэдэгдэж, тухайн тодотгох асуудалтай холбогдох анхан шатны баримтыг нэмж үзүүлэхийг шаардах эрхтэй бөгөөд танай харилцагч байгууллагуудаас албан хүсэлтээр мэдээлэл цуглуулж шалгалтанд ашиглана.

ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН АЖИЛТНУУД, ЗӨВЛӨХ ОРОЛЦУУЛАХ

□ Байцаагч шалгалтын үйл ажиллагаатай холбогдуулан танай ямар ч мэргэжлийн зөвлөлтэй ажиллахад бэлэн байдаг. Иймд Татвар төлөгч та шалгалтын хугацаанд нягтлан бодогч, эдийн засагч, зөвлөх зэрэг мэргэжлийн хүмүүсийг байлцуулж тайлбар тодруулгыг тухай

бүр нь гаргана. Та шалгалтын аль ч үед эрхээ эдэлж болно.

□ Харин таны зөвлөх байцаагчид шаардлагатай асуудлуудад бүрэн гүйцэд хариулт өгч чадахааргүй бол байцаагч энэ тухай танд мэдэгдэж, тантай шууд харилцах болно.

□ Та хэдийгээр татварынхаа тооцоо, тайланг нягтлан бодогч буюу мэргэжлийн зөвлөхөөрөө хийлгэдэг байсан ч гэсэн татварын хуулинд зааснаар татвар төлөгч та өөрийнхөө татвартай холбоотой бүхий л асуудлууд болон байцаагчид гаргаж өгсөн мэдээллийн үнэн зөвийг өөрөө л хариуцах үүрэгтэй.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЭЛ АВАХ

□ Байцаагч шалгалтын явцад тантай болон таны төлөөллийн ажилтнуудтай шалгалттай холбоотой бүхий л асуудлын талаар хэдэн ч удаа ярилцлага хийж мэдээлэл авч болно. Ямар мэдээлэл шаардлагатай байгааг аль болох тодорхой энгийнээр тайлбарлана.

□ Татварын хууль тогтоомж, татварын тооцооллын холбогдолтой татвар төлөгчийн асуулгад татварын байцаагч үнэн зөв хариулт, мэдээллийг өгөх үүрэг хүлээнэ.

□ Татварын алба татвар төлөгч таны бизнесийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг шалгалт эхлэхийн өмнө, шалгалтын явцад танаас болон бусад байгууллага, иргэдээс хүлээн авч, тэдгээрийн үнэн зөв эсэхийг шалгалтын явцад тогтооно.

□ Таны тайлангийн тодорхой үзүүлэлтүүдийг өөрөөр хэлбэл татварын тооцоог бүртгэлийн бичилтүүдээр тулган конторын шалгалт хийх хэлбэрээр шалгалтыг хязгаарлаж болно.

□ Татварын алба сэдэвчилсэн буюу Нэмэгдсэн өртгийн албан татвар, Онцгой албан татвар гэх мэт тодорхой төрлийн татварын төрлөөр эсвэл иж бүрэн хяналт шалгалтыг хийдэг. Иж бүрэн хяналт шалгалт нь таны төлдөг татваруудын татвараа үнэн тодорхойлж тогтоосон хугацаанд төсөвт төлсөн эсэхэд анхан шатны баримт болон санхүү, татварын тайлан, бусад хөндлөнгийн мэдээллийг ашиглан хяналт шалгалт хийнэ. Татварын сэдэвчилсэн шалгалт гэдэг нь тодорхой төрлийн татварын хяналт шалгалт хийхийг хэлдэг.



Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үе дэх татварын алба, татвар төлөгчийн харилцааны тухай зөвлөмж /үргэлжлэл/

Хэрэв байцаагч танаас таны татварын тайлан дахь бичилтүүдтэй холбоотой баримт бичиг, холбогдох бусад материалыг гаргаж өгөхийг шаардвал та энэ мэдээллүүдийг түргэн шуурхай гаргаж өгөх үүрэгтэй. Хэрэв байцаагчид өөр мэдээлэл хэрэгтэй бол тэр тухай хүсэлтээ танд тайлбарлах болно.

Таны цагийг аль болох бага зарцуулах үүднээс байцаагч юу үзэж, шалгахаа тайлбарлана. Татварын албанаас танд аль болох олон асуудал тавихыг хичээхгүй. Хэрэв та шалгалтыг хөнгөн шуурхай богино хугацаанд дуусгахад туслах үүднээс та өөрийнхөө хувийн болон бизнесийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлуудыг татварын байцаагчид тодорхой хэлж өгвөл таны ч, татварын албаны ч цаг хугацаа, зардлыг хэмнэх болно.

Байцаагчийн шаардсан мэдээллийг олоход үнэхээр хүндрэлтэй байгаа бол хариу мэдэгдэх нь зүйтэй. Бид энэхүү мэдээллийг яаж олж авах тухайгаа хамтран ярилцаж шийднэ. Та мөн энэ мэдээлэл бидний тавьсан шаардлагатай холбоогүй гэдгийг хэлж болно. Таны тавьсан хүсэлтийг бид анхааралтай авч үзнэ. Хэрэв энэ мэдээлэл бидэнд шаардлагатай хэвээр байгаа бол түүнийгээ танд мэдэгдэж тайлбарлана.

Хэрэв байцаагч танаас хүссэн мэдээллээ авч чадахгүйд хүрвэл мэдээллээ авахын тулд хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх болно. Эхлээд хуулиар олгогдсон эрхээ тайлбарлаж, шаардлага биелүүлээгүй тохиолдолд хуулинд заасан хариуцлага ногдуулахад хүрэх болно гэдгийг анхааруулна.

Таны өгсөн мэдээлэл үнэн зөв байх ёстой. Та буруу мэдээлэл өгвөл энэ нь хууль зөрчиж байгаа тул хариуцлага хүлээх болно.

Байцаагч яагаад шалгалтаа томилолтонд заасан хугацаанаас илүү хугацаагаар үргэлжлүүлээд байгааг та асуух эрхтэй. Хэрэв та түүнийг үндэслэлгүйгээр шалгалтын ажиллагааг удаашруулж байна гэж үзэж байгаа бол гомдлоо гаргаж шалгалтыг дуусгаж үр дүнг гаргахыг шаардаж болно. Жишээлбэл: Та тайланг бүрэн зөв болгоход шаардагдах бүх мэдээллийг өгсөн, эсвэл шалгалт шалтгаангүй удсан гэж үзэж байгаа бол...

ТАВ. УУЛЗАЛТ

Тантай татварын улсын байцаагч хяналт шалгалттай холбоотой асуудлаар уулзаж ярилцахаар хүсэлт тавьж болно.

Уулзалтын үед та өөрийн

мэргэжлийн нягтлан бодогч, өмгөөлөгчөө байлцуулах хүсэлт тавьж болно.

Та аливаа уулзалтанд заавал ирэх нь зүйтэй. Уулзалтууд нь байцаагч ойлгомжгүй байгаа зүйлээ танд тайлбарлах, тодотгох боломж олгохоос гадна та асуулт тавьж болно шүү дээ.

Уулзалтын үеэр та хариулж байгаа хариултынхаа үнэн зөвийг хариуцна. Хэрэв та хариултдаа итгэл муутай байвал түүнийгээ хэлэх ёстой. Үүний нэгэн адил уулзалтын дараа буруу хариулснаа ойлговол энэ тухайгаа байцаагчид шууд мэдэгдэх хэрэгтэй.

Аливаа уулзалтын тухай байцаагч бичлэг хийж болох ба та түүний нэг хувийг авч болно.

Уулзалтын тэмдэглэлд байцаагч танаар гарын үсэг зуруулж, таны юу хэлсэнтэй нийцэж буйг баталгаажуулна. Та энэ тэмдэглэлд саналаа тэмдэглэх болон байцаагчтай чухам юун дээр санал нэг биш байгаагаа хэлэх эрхтэй. Энэ нь аливаа шийдвэр гарахад чухал бичиг, баримт болох үндэслэлтэй.

ЗУРГАА. ХЭРЭВ ТА ЗӨРЧИЛГҮЙ БОЛ

Хэрэв хяналт шалгалтаар татварын хууль тогтоомжийг сайтар биелүүлсэн ямар нэг зөрчил илрээгүй бол та байцаагч энэ тухай танд мэдэгдэж, илтгэх хуудас бичин танаар гарын үсэг зуруулж шалгалтаа дуусгана.

ДОЛОО. ЯМАР НЭГ ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛБЭЛ

Хэрэв хяналт шалгалтаар зөрчил илэрсэн бол байцаагч нь зөрчлийн утга агуулга, тоо хэмжээ зөрчил гарах болсон шалтгааныг нэг бүрчлэн танд тайлбарлаж өгөх болно.

Цаашид татварын тайлан, тооцоогоо хэрхэн хуулийн дагуу зөв хийхийг зааж зөвлөнө.

Зөрчил гаргасан үйлдэл, хэмжээнд татварын улсын байцаагчийн актаар нөхөн татвар, торгууль, хүү, алданги ногдуулна.

Таны гаргасан татварын зөрчилд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын улсын байцаагч нөхөн татварыг төлүүлж, нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна.

Байцаагч таныг татвараа хугацаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй татварын дүнд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна.

Нөхөн төлүүлэх болон хугацаанд нь төлөөгүй татварт алданги тооцох бөгөөд уг алдангийн хэмжээ нь нөхөн төлүүлэх татварын үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхээргүй байна. Алданги тооцох хувь хэмжээг Засгийн газар жил

бүр батлан гаргадаг ба 2014 онд 0,051 гэсэн хувь үйлчилж байна.

Байцаагч гаргасан акт, хавсралт тооцоо, тэмдэглэлээ танд танилцуулж таны зөвшөөрсөн эсэхийг тодруулан тайлбар авч гарын үсэг зуруулж, нэг хувийг танд гардуулна. Татварын улсын байцаагчийн акт нь танилцуулж, гардуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

НАЙМ. ТАНЫ ЭДЛЭХ ЭРХ, ТАЙЛБАР, ГОМДОЛ ГАРГАХ

Татвар ногдуулалт, төлөлт, хяналт шалгалтын дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх, гомдол гаргах

Татварын улсын байцаагчийн тавьсан акт, материалтай танилцах

Татварын албаны буруугаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх

Хэрэв энэ зөвлөмж зөрчигдсөн, хяналт шалгалтын явцад таны эрх зарим талаар зөрчигдөн байцаагч алдаа гаргаж тантай буруу харилцсан гэж үзвэл та гомдлоо тухайн байцаагчийн харьяалах тасаг, хэлтсийн дарга болон шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Хэрэв та байцаагчийн актыг зөвшөөрөхгүй бол энэ тухай үндэслэл, тайлбараа гаргаж Маргаан таслах зөвлөлд танилцсанаас хойш 30 хоногийн дотор хандах эрхтэй. Маргаан таслах зөвлөл таны гомдлыг хүлээн авсан бол зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Энэхүү хурлаар таны гомдлыг бүтнээр нь буюу хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх эсвэл гомдол үндэслэлгүй байгаа талаар тогтоол шийдвэр гаргана.

Та Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол дараагийн шатны Маргаан таслах зөвлөл эсвэл шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ЁС. НУУЦ ХАДГАЛАХ

Татварын алба болон татварын улсын байцаагч нар албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн Хувь хүний болон байгууллагын нууцын тухай хуулиар тодорхойлсон татвар төлөгчийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн нууцыг чанд хадгалах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ чанд биелүүлж ажилладаг гэдэгт та итгэлтэй байж болно.

Зохион байгуулагдсан ажлууд

- 10-р сарын 13-17 өдрүүдэд БУТ-н тэнхим сурталчлах өдөр боллоо.
Даваа гарагт - Өдөрлөгийн нээлт, МОХ-н төлөөлөгч оюутан залууст лекц, хэлэлцүүлэг хийж,
Мягмар гарагт – 1-р курсын хамт олон “Алтан хонх” танин мэдэхүйн уралдаант тэмцээн,
Лхагва гарагт 2-р курсын хамт олон Маркетингийн өдөрлөг /оюутны бүтээлийн танилцуулга, бизнес ба дуудлага худалдаа үйлчилгээ/,
Пүрэв гарагт 4-р курсын хамт олон “Шилдэг санхүүч” уралдаант тэмцээн, Баасан гарагт Уламжлалт ширээ засалтын тэмцээн амжилттай зохион байгуулаад өдөрлөгийн хаалтаа хийж шагналаа гардуулсан бөгөөд бидний энэхүү үйл ажиллагаанд сургуулийн нийт багш оюутнууд идэвхтэй оролцлоо.

- Сургуулийн “Halloween party ” 10-р сарын 30 нд болж багш оюутан залуус нэгэн өдрийг хөгжилтэй сайхан өнгөрөөлөө.



“Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг “Ростехнологи” корпораци эзэмшинэ



УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцлээ.

Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр болон “Монголросцветмет” нэгдлийн 51 хувийг Монгол, 49 хувийг ОХУ-ын Засгийн газар эзэмшиж байсан. ОХУ-ын Засгийн газар эзэмшлийн хувьцаагаа


“Ростехнологи” корпорацид шилжүүлсэн байна.

Хоёр улсын хамтарсан хэлэлцээрт үүнтэй холбоотой өөрчлөлт оруулах шаардлага гарчээ. Оросын талын хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн учир ногдол ашгийг ОХУ-ын Засгийн газар шилжүүлж байсан бол 2013 оноос эхлэн “Ростехнологи” корпорацийн данс руу шилжүүлэх асуудлыг УИХ-аар шийдвэрлэх гэж буй юм. Өөрийн эзэмшлийн хувьцаагаа хэнд шилжүүлэх нь хувьцаа эзэмшигчийн эрх учир энэ асуудлыг хууль тогтоогчид дэмжээд явуулах хэрэгтэй гэж тус байнгын хорооны гишүүд үзэж, УИХ-аар хэлэлцэхийг дэмжив.

Оросын тал хувьцаа эзэмшигчээ өөрчилснөөс хойш хоёр жил болсон бөгөөд Монголын талаас хамаарах энэ асуудал шийдэгдээгүй учир хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг шилжүүлээгүй байсан аж.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монголд айлчлахдаа тус үйлдвэрийн Оросын талын хариуцах байгууллага өөрчлөгдсөнийг сануулаад, энэ асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүссэн байна. “Хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөнөөр хоёр орны 2003 онд байгуулсан хэлэлцээр өөрчлөгдөхгүй, үйлдвэрийн Оросын талын удирдлагууд солигдож магадгүй” гэж тус байнгын хорооны гишүүн, УИХ-ын дарга З.Энхболд тайлбарлав.

Бизнес эрхлэгчид 353.7 тэрбум төгрөгний татвары өртэй



Засгийн газраас УИХ-д өргөн барьсан “Эдийн засгийн ил тод байдлыг хангах тухай” хуулийн төсөлтэй холбоотойгоор татварын өрийг өршөөх гэж байна гэсэн хүлээлт олон нийтэд бий болсон. Үүнээс үүдэн энэ оны улсын төсөвт төлөх татварын өр 10 дугаар сарын тавны байдлаар 353.7 тэрбум төгрөгт хүрсний 194.2 тэрбум нь барагдуулах боломжтой өр байгаа аж.

Иймд татварын өр барагдуулах чиглэлээр 2014 он дуустал зорилтот ажил зохион байгуулах үүргийг Засгийн газраас холбогдох байгууллагуудад өглөө.

Юуны түрүүнд, Засгийн газраас өргөн барьсан хуулийн бодлого, зохицуулалтыг тайлбарлаж, хуулийн төслийн хүрээнд ногдуулсан татварын өрийг энэ хуулиар чөлөөлөхгүй гэдгийг олон нийтэд ойлгуулах шаардлагатайг Татварын ерөнхий газарт анхаарууллаа. “Эдийн засгийн ил тод байдлыг хангах тухай” хуулийн төсөлд хуулийн дагуу ногдуулсан аливаа татварын өрийг хөнгөлөх, чөлөөлөх асуудал тусгагдаагүй юм.

Аж ахуйн нэгжүүд харилцан зөвшөөрсөн тохиолдолд тухайн татвар төлөгчийн татварын өрийг бусад татвар төлөгчид төсвөөс олгох татаас, санхүүжилт, шилжүүлэгт суутгах замаар татварын өрийн зангилааг тайлах боломжтой. Энэ нь мөнгөн хөрөнгийн дутагдалд орсон аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг болно гэж үзээд, үүнд чиглэсэн ажил зохион байгуулахыг Сангийн яаманд даалгалаа. Түүнчлэн, татварын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд хамтарсан аянаар хуримтлагдсан өрийг богино хугацаанд барагдуулах боломжтойг зөвлөлөө. Одоогийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 94.4 тэрбум төгрөгийн татварын өр шилжүүлснээс 53.4 тэрбум төгрөгийн өрийг барагдуулаагүй байна.

Цаашид өр барагдуулах чиг үүргийг хариуцсан нэгжийг оновчтой зохион байгуулалтад оруулах шаардлагатай гэж Засгийн газрын гишүүд дүгнэлээ.

Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах, гаргах барааны хугацааг нэмэх асуудлыг хэлэлцэв

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны өнөөдрийн /2014.10.08/ хуралдаанаар эхлээд Засгийн газар 2014.10.01-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийг дагаж өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэх байлаа.

Дээрхи асуудлыг УИХ дахь МАН-ын бүлгийн хуралдаанаар хэлэлцэх шаардлагатай байгаа учир тав хоногийн завсарлага авч байгааг УИХ-ын гишүүн, МАН-ын бүлгийн дэд дарга Д.Оюунхорол мэдэгдсэнээр уг асуудлыг хэлэлцэхийг хойшлууллаа. Дараа нь Засгийн газар 2014.09.04-ний өдөр өргөн мэдүүлсэн Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэв. Төсөл танилцуулгыг Зам, тээврийн сайд А.Гансүх хийлээ. Хуулийн төслөөр Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулсан барааг гаалийн нутаг дэвсгэрээс буцаан гаргах хугацаа нь тухайн горимд байршуулсан өдрөөс хойш дор дурдсан хугацаатай байхаар

1-рт Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах талаар Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тос хайх, олборлох, ашиглахад зориулагдсан бараа 3 жил 6 сар хүртэл,

2-рт гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зориулалттай үндсэн техник, тоног төхөөрөмжийн хувьд 2 жил хүртэл,

3-рт иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын хөлөг, түүний сэлбэг, тоног төхөөрөмжийг түрээсийн гэрээний хугацаагаар,

4-рт бусад бараа 1 жил хүртэл байхаар тус тус тусгасан байна.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д. Дэмбэрэл, Ж. Эрдэнэбат асуулт асуун, хариулт авч Улсын Их Хурлын гишүүн С. Баярцогт үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат хүндрэл, бэрхшээл үүсээд байгаа авто замын салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний тоног, төхөөрөмжийг гэрээнд заагдсан хугацаагаар гаалийн нутаг дэвсгэрт түр оруулдаг байхаар өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт гаалийн түр горимтой холбоотойгоор үүсээд байгаа бусад салбаруудыг хамруулж нэгдсэн зохицуулалт хийх нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд зуун хувийн саналаар хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжсэн тул энэ талаарх байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхээр болов. Мөн Төсвийн болон Төрийн байгуулалтын байнгын хороо хамтран хуралдаж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд УИХ-ын гишүүн Д.Оюунхоролын Засгийн газраас өргөн барьсан энэ асуудлыг хэлэлцүүлэх асуудлаас хасья гэсэн горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжлээ.